



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/180

Мандалговь

“Эл Эс Би” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дугаар зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Засаг даргын 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А/59 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх “Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын конторын барилгын ажил”-ын гүйцэтгэгч “ЭЛ ЭС БИ” ХХК-тай 1,139,470,753 (Нэг тэрбум нэг зуун гучин есөн сая дөрвөн зуун далан мянга долоон зуун тавин гурав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу “Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын конторын барилгын ажил”-ыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “ЭЛ ЭС БИ” ХХК-ны захирал (Р.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж)-д, Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190485